**Чимээгүй алуурчид буюу  шимэгчид.**

Шимэгчидийн хор нөлөөгөөр дэлхий дээр олон арван сая хүн өвчинд нэрвэгдэж, ертөнцийн мөнх бусыг үзэж байна. Хамгийн аюултай нь шимэгчлэх өвчнийг илрүүлэхэд маш хэцүү байдаг. Элгэндээ шимэгчдтэй хүн халдвартын эмнэлэгт гепатит/шар өвчин/ оноштойгоор, цөсөндөө шимэгчтэй хүн мэс заслын эмнэлэгт цөсний чулуужилт оноштойгоор, өөрөөр хэлбэл тухайн хүний онош буруу тогтоогдон эмнэлэгт хүргэгддэг тохиолдол  гардаг нь нууц биш юм

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлсэнээр жилд 50 сая хүн нас бардгийн 16 сая нь шимэгчлэх өвчнөөр нас бардаг гэжээ. Шимэгчлэх өвчин нь хүүхдийн бие мах бодь ба сэтгэл зүйн өсөлтийг хязгаарлах шалтгаан болдог бөгөөд насанд хүрсэн хүмүүсийн ажиллах чадварыг бууруулдаг. Халдвар авсан хүмүүсийн бие мах бодид харшил үүсгэн өвчин эсэргүүцэх чадварыг бууруулж, урьдчилан сэргийлэхэд хэрэглэдэг тарианы үр нөлөөг багасгана.

2001 онд хуралдсан ОУ-н Эрүүл Мэндийн Ассамблейн 54-р чуулганаас 2010 он хүртэл шимэгчлэх өвчинтэй тэмцэх хөтөлбөр гаргасан. Хүн хэдийгээр сансрын хөлөг хүчтэй зэр зэвсэг бүтээн далай тэнгисийг эзэмдэх болсон боловч шимэгчдийг устгаж дийлэхгүй байна.

АНУ-н эрдэмтэн Росс Андерсэн 20 жилийн турш шимэгчдийг судлаад “ Шимэгчид нь бидний бие организмд үүрлэн амьдрахдаа бидний шимтэй бүхнийг булаан идчихээд организмыг бохирлон хор ялгаруулж өвчний эх үүсвэр болж байдаг” гэжээ. Шимэгчид нарийн, бүдүүн гэдэс, уушиг, элэг, цөс,цөсний суваг,цус, яс, булчин,тархи, нүд гээд ер нь үүрлэж болох бүхий л газарт суурьшиж чаддаг, маш олон янзын хэлбэр дүрс хэмжээтэй.

ДЭМ –н байгууллагын судалгаагаар Африкийн хүн тус бүр 2-с доошгүй, Ази болон латин америкийн орнууд 1-с дээш, Европынхон 3 хүн тутмаас 1-нь ямар нэгэн шимэгчтэй байдаг гэж тодорхойлсон.. Шимэгчээр халдварлагдах явдал нь тухайн орны эдийн засгийн төвшин ба хувь хүний ариун цэвэр соёлоос ихээхэн хамаардаг.

Маш өчүүхэн жижгээс аврага том динозаврууд хүртэл байдаг, 10 м урттай туузан хорхой хүртэл илэрсэн. Энэ нь ямар нэгэн байдлаар нугарч байрлан, гэдэсний хөндийг дүүргэж, бүх жингээрээ гэдэсний ханыг дарах бөгөөд ингэж гэдэс түгжирснээс нойрсуулалтад орж, мэс засал хийлгэх, гэдэсний хана холгож цоорох, язрах, хэвлийн үрэвсэл болж, мөн мэс засалд орох зэрэг аюулд хүргэдэг.




Тэдгээрийн үүрлэн бэхлэгдэх нь янз бүр байж, дэгээ соруул зэрэг  зохилдлоготой бөгөөд зөвхөн ходоод гэдсэнд ч биш хаана амьдрах таатай нөхцөл бүрдэнэ тэндээ амьдарч эхэлдэг. Ж: ЭХИНОКОК нь элэгнээс

гадна хүний тархинд, зүрхэнд үрждэг.

Энэ тохиолдолд тархины хавдар үүсэх нөхцлийг дэврээж, тархины хальс хатингаршсанаас цусан хангамж муудлаг. Зарим шимэгчид цөс ялгаруулах сувагт байрлан идээшиж, цөсний урсгалыг бүрэн хаадаг талтай. Ийм өвчтөнүүд халдварт өвчтөний эмнэлэгт гепатит, эсвэл мэс засалд цөсний чулуужилт оноштойгоор цөөнгүй хүргэгддэг.

Үнэндээ шимэгчид хүнийг чимээгүйхэн тонодог бөгөөд хүнээс чухал шаардлагатай шим тэжээлийг нь хангалттай булаадаг. АНКИЛОСТОМА гэдэг шимэгч анкилостомоз өвчин үүсгэгчид бөгөөд гэдэсний хананаас цус сорох чадвартай, эзнийхээ биед удаан хугацаагаар байснаас цус багадах өвчинг үүсгэнэ.




Хордлого ба харшлын илрэлүүд шимэгчлэлийн үр дагавар байдаг. Арьсны элдэв идээ шарх зэрэг нь мөн шимэгч болон мөөгөнцөр бактертай холбоотой юм. Шимэгчид хүнээс шим тэжээлийг идэж хорт ялгадсаар хүнийг бохирлоод зогсохгүй, хүнийг удирдан жолоодож чаддаг гэдэгт та итгэх үү.Ж: АНУ-н маш хэрцгий хүнд хэрэг хийсэн хоригдлуудад судалгаа хийхэд тэдний 95% -нь тархиндаа шимэгчтэй байсан бөгөөд байнга зөрчил гаргаад байдаг хүмүүсийн 65% -нь шимэгчтэй байжээ.

Зарим хүүхдүүд чихэрлэг юманд хэт дурлан хоол унд тоохгүй болчихсон байдаг. Ийм хүүхдүүд ихэвчлэн хоол боловсруулах зам, ходоод гэдсэндээ лиамбли хэмээх нэг төрлийн шимэгчтэйгээр олонтаа оношлогдож байна. Өөрөөр хэлбэл шимэгч нь тэр хүүхдийг тэсэхийн аргагүй чихэрт дурлуулж байна

. Манай компьютер оношилгоогоор монголчуудын дунд элгэнд болон цөс , хоол боловсруулах замд опсторхоз, ляамбли, токсоплазма гонди, зэрэг шимэгчид нилээд ихээр оншлогдож байна. Мөн хэт их хяналтгүй хэрэглэсэн эм тарианаас үүдэлтэй мөөгөнцөр ихээр илэрч байна.

Ер нь шимэгчдийн талаар хамгийн бага судлагдсан бөгөөд харамсалтай нь орчин цагийн анагаах ухаанд шимэгчийн гаралтай өвчний оношлогоо эмчилгээ шаардлагаас хоцорсон

. Бидний биеийн тодорхой хэсэгт үүрлэн биеийн жингийн тодорхой хэсгийг эзлэх тохиолдол ч байдаг. Тэднийг хүчтэй эмээр устгаж болохгүй бөгөөд бидний элэг бөөр тэр их ачааллыг даахгүйн улмаас, хүн маш гүн хордлогод орох тохиолдол гардаг.



Шимэгчийн эсрэг байгалийн цэвэр бүтээгдхүүн бидэнд бий .Хэрэв шимэгч таны биед үүрлэн 2-с дээш жил болсон бол та нэг удаагийн цэвэрлэгээгээр шимэгчээс салж чадахгүй .2-3 дахин давтан хийх шаардлагатай. Эрүүл аж төрөх үүднээс та жилд 2-с доошгүй удаа шимэгчийн цэвэрлэгээг хийж байх нь чухал юм.

Хэрэв ингэж хийдэггүй бол эдгээр шимэгчдийг хооллож байна гэсэн үг, тэд амьдарсаар үржсээр л байх болно. Манай компьютер оношлогооны аппарат нь ямар төрлийн өвчин үүсгэгчид, шимэгчид, вирус бактерууд ямар эрхтэнд байрлаж байгааг төвөггүй тогтоож чаддаг. мөн тэдгээрийг хэрхэн бие организмаас  зайлуулах арга механизмыг зөвлөж чаддагаараа давуу юм.